

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 10 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 05 минутад эхэлж, 11 цаг 06 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 01 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Ховд, Увс, Сэлэнгэ аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 03 дугаар сарын 06-11-ний өдрүүдэд Ховд, Увс, Сэлэнгэ аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Ховд, Увс, Сэлэнгэ аймагт 2014 оны 03 дугаар сарын 06-11-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 138 иргэнээс 104 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 34 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 40</p>

		<p>иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 15 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 7, 8, 9, 10, 11, 12 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 7-12 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 55 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Ховд, Увс, Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн даргад тус тус үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>УИХ-ын Тамгын газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай /бүтцийн өөрчлөлтөөр/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн</p>

		<p>П.Мядагмаа, Д.Энэбиш, Ц.Алтан-Од нарыг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн П.Мядагмаа, Д.Энэбиш, Ц.Алтан-Од нарыг төрийн захиргааны албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. П.Мядагмаа, Д.Энэбиш, Ц.Алтан-Од нарыг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын 2014 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн ЗГ-2/56 тоот албан бичиг, захиалгаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй зарлаж, зохион байгуулахаар тогтов.</p>

4	Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн Ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний 3)-т “Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга” гэснийг “Цагдаагийн ерөнхий газрын Дэмжлэг үзүүлэх асуудал эрхэлсэн дэд дарга” гэж, 4)-т “мөн газрын Захиргааны удирдлагын газрын дарга” гэснийг “Дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн дэд дарга гэж”, 5)-д “мөн газрын Бодлого, зохицуулалт, үнэлгээний хэлтсийн дарга” гэснийг “Гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга” гэж, 6)-д “мөн газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга” гэснийг “Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга” гэж, 7)-д “мөн газрын Хуулийн хэлтсийн дарга” гэснийг “Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга” гэж, 8)-д “Дотоодын цэргийн штабын дарга” гэснийг “Хуулийн хэлтсийн дарга” гэж, 9)-д “Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн ахлах байцаагч” гэснийг “Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн” гэж тус тус өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Бусад асуудал	1. Төрийн албаны зөвлөлөөс 2014 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Зам,

		<p>тээврийн яаманд хүргүүлсэн 349 тоот албан бичиг, санал нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй байх тул уг албан тоотыг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргад үүрэг болгох,</p> <p>2. Зам, тээврийн яамны Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газрын даргын ажлын байрны сул орон тоог нийтэд нээлттэй зарлах,</p> <p>3. Зам, тээврийн яамны хүний нөөцийн үйл ажиллагаанд Төрийн албаны зөвлөлөөс шалган, зааварлах ажиллагааг явуулахаар шийдвэрлэв.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ